



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/11/-НА-СТА-УТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn
---	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



АЛТАЙ УСАН СПОРТ
ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ М.МЯГМАРБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 03. 15 № 166
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тушаал шийдвэргүй нэмэгдэл авсан, илүү цагийн хөлс олгосон, цалин зөрүүтэй олгосон зэрэг 4.0 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 14.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


07020436

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	6,233,984.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	404,748.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	404,748.13
3121	Төгрөг	-	404,748.13
31213	Арилжааны банк дахь харилцах	-	404,748.13
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,829,236.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	5,575,236.00
354	Хангамжийн материал	-	254,000.00
35420	Аж ахуйн материал	-	254,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	4,229,878,186.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	4,229,878,186.05
392	Биет хөрөнгө	-	4,227,140,686.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	4,078,212,998.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	- 81,674,500.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	220,981,888.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	- 25,177,454.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	19,189,840.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	- 1,510,835.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	19,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	- 2,681,250.00
393	Биет бус хөрөнгө	-	2,737,500.00
39301	Програм хангамж	-	2,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	- 82,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	4,236,112,170.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	4,236,112,170.18
51	Засгийн газрын хувь оролцоо	-	4,236,112,170.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	4,199,545,086.84
51101	Өмч: - төрийн	-	4,199,545,086.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		177,091,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		26,998,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		26,998,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,800,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,800,000.00
120005	Түрээсийн орлого		298,400.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		23,899,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		150,093,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		150,093,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		150,093,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		140,524,516.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ		140,524,516.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		140,524,516.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		140,524,516.66
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		133,938,463.36
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/		4,986,403.30
210813	Бусад зардал /ТӨҮГ/		1,599,650.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		36,567,083.34
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		36,567,083.34

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	4,199,545,086.84	0.00	0.00	0.00	4,199,545,086.84
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	36,567,083.34	0.00	36,567,083.34
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,199,545,086.84	0.00	36,567,083.34	0.00	4,236,112,170.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		174,739,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		24645600.00
120	Нийтлэг татварын бус орлого		24645600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		24645600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		24,645,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		150,093,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		150093600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		150,093,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		136,156,955.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ		136,156,955.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		136,156,955.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		40,076,306.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		40,076,306.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		11,740,056.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		11,740,056.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		62,001,552.87
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		62,001,552.9
2104	Хангамж, бараа материалын зардал		17,076,646.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		17,076,646.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,262,395.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		3,215,145.0
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		2,047,250.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		38,582,244.13
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		38,177,496.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		38,177,496.00
2200	Дотоод эх үүсвэрээр		38,177,496.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		38,177,496.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		- 38,177,496.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		404748.13
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		404,748.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Борлуултын орлого	25,718,800.0	24,198,000.00	1,520,800.0	94%
Том хүн 1 сард 8 удаа сэлэлт	5,900,000.0	4,960,000.00	940,000.0	84%
Хүүхэд 1сард-8 удаа сэлэлт	17,440,000.0	16,746,200.00	693,800.0	96%
Гэрээт байгууллага 1 сард-4 удаа	1,500,000.0	1,408,400.00	91,600.0	94%
Алтай орон сууцны түрээсийн орлого	223,800.0	298,400.00	(74,600.0)	133%
Хувцасны үнэ ашиг 50%	600,000.0	250,000.00	350,000.0	42%
Чөлөөлт сэлэлт	55,000.0	105,000.00	(50,000.0)	191%
Сауны орлого	-	430,000.00	(430,000.0)	0%
санхүүгийн дэмжлэг	150,171,805.0	150,093,600.00	78,205.0	100%
ОРЛОГО	175,890,605.0	174,291,600.0	3,119,805.0	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		9,682,590.00	(9,682,590.0)	0%
1.3 Нийт ашиг	175,890,605.00	164,609,010.00	12,802,395.00	94%
Үйл ажиллагааны зардал	130,279,509.0	124,255,873.36	6,023,635.6	95%
Бусад зардал	45,611,096.0	1,599,650.00	44,011,446.0	4%
Элэгдлийн зардал	140,589,371.0		140,589,371.0	0%
Удирдлагын зардал	26,225,747.0	4,986,403.30	21,239,343.7	19%
Татварын өмнөх ашиг	-		-	0%
Цэвэр ашиг/алдагдал	-		-	0%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн		130,841,926.66	(130,841,926.7)	0%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	-	33,767,083.34	(33,767,083.3)	0%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-	33,767,083.34	(33,767,083.3)	0%
Татвараас чөлөөлөгдөх зардал			-	
Татвар төлөх ашиг алдагдал	-	33,767,083.34	(33,767,083.3)	-
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	-	33,767,083.34	- 33,767,083.34	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дүгээр сарын 04-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар нь “Аймгийн тамирчдыг олимпод бэлтгэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, аймгийн хэмжээнд усан спортыг хөгжүүлэх, сургалт хүмүүжлийн үйлчилгээг эрхлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллага шинээр үүсгэн байгуулагдсан учир байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлийг мөрдөн ажиллаж байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компани нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Иймээс Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болон мөрдөн ажиллах нь зүйтэй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 174.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 131.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын зорилго нь аймгийн тамирчдыг олимпод бэлтгэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, аймгийн хэмжээнд усан спортыг хөгжүүлэх, сургалт хүмүүжлийн үйлчилгээг эрхлэн ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг аймаг, орон нутгийн тамирчдыг олимпод бэлтгэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, аймгийн хэмжээнд усан спортыг хөгжүүлэх, сургалт хүмүүжлийн үйлчилгээ, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх, дүрмээр зөвшөөрсөн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх, холбогдох, дүрэм, эрх зүйн баримт, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн болон Засаг даргын шийдвэрийг ханган ажиллана гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд спортын бусад үйл ажиллагаа гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дүрмийн 2021 оны 37 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах,” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 37 дугаар тогтоолоор томилж байгаа нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль 35.1.12-т “орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх” заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим

болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, нэг ажилтанд шагнал олгосон, чиг үүргийн давхардлыг арилгалгүй орон тоог тайлант оны 11-12 дугаар сард 3 орон тоогоор нэмж ажиллуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 53 дугаар тогтоолоор тус үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулж, 15 бүтэц орон тоо, 2021 оны 05 сарын 31-ны өдрийн 37 дугаар тогтоолын дүрмийг баталсан.
- Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
	1	2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Мөнгөн хөрөнгө	0	404.7	+404.7
БХХО	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	0	5,829.2	+5,829.2
Үндсэн хөрөнгө	0	4,227,140.7	+4,227,140.7
Биет бус хөрөнгө	0	2,737.5	+2,737.5
Нийт хөрөнгийн дүн	0	4,236,112.2	+4,236,112.2
Өр төлбөрийн дүн	0	0	0
Богино хугацаат өглөг	0	0	0
Урт хугацаат өглөг	0	0	0
Эздийн өмч	0	4,236,112.2	+4,236,112.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0	4,236,112.2	4,236,112.2

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 0.4 сая төгрөг байна.

Авлага дансанд үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.8 сая төгрөг болсон. Тайлант онд худалдан авалтаар 17.1 сая төгрөгийн бараа бэлэн бүтээгдэхүүн, аж ахуйн материал нэмэгдсэн, 11.2

сая төгрөгийг зарцуулсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн дансанд шинээр 38.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, хандиваар 2.8 сая төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдэж, Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 4,300.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн авсан байна. Биет бус хөрөнгө 2.8 сая төгрөгөөр өссөн нь программ хангамж худалдан авсантай холбоотой. Бусад эргэлийн бус хөрөнгөнд 4,229.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан ч ашигтай ажилласан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт холбогдох зардлуудыг хамруулсан байна. Зардлын өртөгт хуваарилагдахгүй зардал байхгүй байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 105 дугаар тогтоолоор "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 175.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 175.9 сая төгрөгөөр, ашиг /алдагдал/-гүй ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 40.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 177.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 144.2 сая төгрөгийн зардал гарган, 36.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 177.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 3.1 сая төгрөг буюу 1 хувиар өссөн байгууллагын хандив тусламжийн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 144.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 35.4 сая төгрөг буюу 22 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагааны зардал буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 36.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 36.6 сая төгрөгөөр илүү байгаа нь зардлыг багассантай холбоотой байна.

Түрээсийн төлбөрийн 60 хувь болох 0.4 сая төгрөгийн түрээсийн орлого орон нутгийн орлогод төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 26 мэдээллээс 2 төрлийн 9.9 сая төгрөгийн худалдан авалт, зарлагын гүйлгээг, 14 төрлийн 174.7 сая төгрөгийн орлогыг, 2 төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 И-баримттай холбоотой

И-баримтгүй 1.9 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинээр үүсгэн байгуулагдсан тул завсрын аудит хийгдээгүй, өмнөх зөвлөмж байхгүй

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар:

- ✓ Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах,
- ✓ төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэх
- ✓ Илүү цагийн бүртгэлийг тулган баталгаажуулах
- ✓ Тушаал шийдвэртэй холбоотой зардлыг тулган баталгаажуулалтыг үзэх нь зүйтэй.

Түрээсийн төлбөрийг 0.2 сая төгрөгийн алданги тооцоогүй байна. Иймээс гэрээг мөрдөн ажиллах. Эрхийн бичиг, урилгаар явж байгаа иргэний, эрхийн бичиг, урилгын хяналт тавих. Ажилчдын ажиллах цагийн хуваарь, бүртгэл эмх цэгцгүй, тодорхойгүй, хяналт сул байгаа

тул удирдлагын хяналтыг сайжруулах. Хүүхдийн байгууллагатай хийсэн гэрээнд заасан хүүхэд усан бассейнд яваагүй байтал орлогыг тооцоо нийлээгүй, буцаан олгоогүй байна. Цаашид хяналт, бүртгэлийг сайжруулахад анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40.8 сая төгрөгийн алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Нийт 1.5 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн. Санхүүгийн тайланд 3.8 сая төгрөгийг, мөнгөн гүйлгээний тайланд 35.5 сая төгрөгийн залруулга хийсэн.

4.2.2 Төлбөрийн акт

Илүү цагийн хөлсийг 2.2 сая төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Захирал нь өөртөө тушаал шийдвэргүй 0.9 сая төгрөгийн нэмэгдэл авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь заалт /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 37 дугаар тогтоолын "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын дүрмийн 7.1-т "Аймгийн Засаг дарга нь "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ-ын захиралтай гэрээ /контракт/ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг гарган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ", " 7.2-т "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын захирлын цалин, шагнал, урамшуулал, хангамж, өмч хөрөнгийн захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг хууль, тогтоомж дагуу нийцүүлэн тогтооно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тушаалаас зөрүүтэй 0.8 сая төгрөгийн илүү, 0.1 сая төгрөгийн дутуу цалин бодож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-т "Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ". "Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 107 дүгээр тогтоол, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын захирлын 2021.09.10-ны өдрийн Б/02, Б/08, Б/10 дугаар тушаал" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

И-баримтгүй 1.9 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон

ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим системд түүвэрлэн үзэхэд 26 мэдээлэл мэдээлэхээс 18 мэдээлэл мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн сан нь санхүүгийн тайлангийн засгийн газрын хувь оролцоотой 4,199.5 сая төгрөгийн зөрүүтэй нь Энэ нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2-т "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ", 8.2.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аймгийн засаг даргад

1.1 Илрүүлэлт: Аймгийн Засаг дарга нь аймгийн ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг дүгнээгүй, байгууллагын удирдлагатай гэрээ байгуулаагүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Говь-Алтай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 37 дугаар тогтоолын хавсралт "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын үлгэрчилсэн дүрэм" улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай тогтоолын 7.1-т "Аймгийн Засаг дарга нь "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын захиралтай гэрээ /контракт/ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг гарган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын захиралд:

2. Санхүүгийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"; гэж заасны дагуу холбогдох хууль эрх зүйн хүрээнд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох

Аймгийн татварын хэлтэст:

3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Нийт орлогын дүн 50 сая төгрөгөөс дээш байтал нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-т "өрийн төлбөрийг бараа шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх замаар барагдуулсан бол үнийн дүнгээр" гэсэн заалтын дагуу холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар	8	44.9	2	40.8	3	4.0	1	0	3	0
Дүн		8	44.9	2	40.8	3	4.0	1	0	3	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар	2	1.9					2	1.9		
Дүн		2	1.9					2	1.9		
Нийт дүн		10	46.7	2	40.8	3	4.0	3	1.9	3	0